



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БЭРХ ХОТЫН ЗАХИРАГЧИЙН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Бэрх хот

Захирагчийн ажлын албаны бүтэц,  
албан тушаалын жагсаалт батлах тухай

Монгол Улсын “Хот тосгоны эрх зүйн байдлын тухай” хуулийн 25 дугаар зүйлийн 25.1, 10 дугаар зүйлийн 10.4, 10.6, 10.7 дах заалт, Монгол Улсын “Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын” тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.2, 68.1, 68.4, 68.6, 69.2, 69.3 дах заалт, “Төсвийн тухай” хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.12, 16 дугаар зүйлийн 16.5.3 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, албан тушаалын жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар баталсан бүтэц, албан тушаалын хүрээнд хүний нөөцөө бүрдүүлж ажиллахыг Захирагчийн ажлын албаны дарга (Э.Мягмарсүрэн)-д даалгасугай.

3.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Хотын захирагчийн 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн А/02 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГЧ  Ч.ЭНХЖАВХЛАН

232 601 002

Хотын Захирагчийн 2026 оны  
 01 дүгээр сарын 02 ны өдрийн  
 01/01 дүгээр захирамжийн хавсралт

Д/д	Албан тушаалын нэр	Албан тушаалын ангилал зэрэглэл	Орон тоо
<b>Нэг. Удирдах албан тушаалтан</b>			
1	Хотын Захирагч	УТ	1
2	Захирагчийн орлогч	УТ	1
3	Захирагчийн ажлын албаны дарга	ТЗ-5 ахлах түшмэл	1
<b>Нийт</b>			<b>3</b>
<b>Хоёр. Санхүүгийн алба</b>			
1	Санхүүгийн албаны дарга	ТЗ-7 дэс түшмэл	1
2	Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн	ТЗ-8 дэс түшмэл	1
3	Нягтлан бодогч	ТҮМ-7	1
4	Нярав	ТҮ-4	1
<b>Нийт</b>			<b>4</b>
<b>Гурав.</b>			
1	Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9 дэд түшмэл	1
2	Хүнс, жижиг дунд үйлдвэр, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9 дэд түшмэл	1
3	Хууль, эрх зүй, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн	ТЗ-9 дэд түшмэл	1
4	Архив, бичиг хэргийн эрхлэгч	ТҮМ-3	1
5	Жолооч	ТҮ-3	1
6	Жижүүр	ТҮ-1	3
7	Хог тээврийн жолооч	ТҮ-3	1
8	Цахилгаанчин, Сантехникч	ТҮ-3	1
9	Үйлчлэгч	ТҮ-1	2
<b>Нийт</b>			<b>12</b>
<b>Бүгд</b>			<b>19</b>